



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Я.АМАРЖАРГАЛ

БАТЛАВ.



АЙВИКО ИНТЕРНЭШНЛ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Л.ЦЭРЭНДОРЖ

**ШИНЭ ТӨРЛИЙН КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД
БОЛОН ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ҮЕД ШААРДЛАГАТАЙ ЭМ ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ, ЖИЖИГ ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар № 421

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Айвико интернэшнл ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Шинэ төрлийн коронавируст халдвар (КОВИД-19)-ын үед шаардлагатай **Багц-7** “Гепарин 5000 ОУН-5 мл” худалдан авах гэрээг (цаашид “бараа” гэх) **88,000,000** (наян найман сая) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

Д/Д	Барааны нэр, төрөл	Багцын дугаар	Үйлдвэрлэгч, Улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /НӨАТ орсон/	Нийт үнэ
1	Гепарин 5000 ОУН-5 мл	7	Монгол	Ширхэг	11,000	8,000	88,000,000
2							
	Нийт дүн						88,000,000

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 88,000,000 (наян найман сая) төгрөгийг Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь 1 нэр төрлийн барааг 2020 оны 11 дүгээр сарын ...-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын-ний өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг¹;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 2. Санхүүжилтийн хуваарь

Д/Д	Барааны нэр, төрөл	Багцын дугаар	Урьдчилгаа /төгрөг/ 50%	Гүйцэтгэл /төгрөг/ 50%
1	Гепарин 5000 ОУН-5 мл	7	44,000,000	44,000,000
Нийт дүн				88,000,000

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Нэр томъёо


Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) “Гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тохиролцсон бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.


26. Маргааныг шийдвэрлэх (ГЕН-ийн Зүйл 26)	
ГЕН 26	ГЕН-ийн 26-д хамаарах тусгай нөхцөл байхгүй
27. Гэрээнд ашиглах хэл (ГЕН-ийн Зүйл 27)	
ГЕН 27.1	Монгол хэл
28. Гэрээнд мөрдөх хууль(ГЕН-ийн Зүйл 28)	
ГЕН 28.1	Гэрээнд Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөнө
29. Мэдэгдэл (ГЕН-ийн Зүйл 29)	
ГЕН 29.1	Эрүүл мэндийн яам, Засгийн газрын 8 дугаар байр, Улаанбаатар-48, Олимпийн гудамж-2
30. Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)	
ГЕН 30	Монгол Улсын нутаг дэвсгэрийн гаднаас болон дотоодоос нийлүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодисыг зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэн ХӨСҮТ-д болон эцсийн цэгт захиалагчид хүргэх хүртэл оногдуулсан бүх татвар хураамж, тээвэр, даатгал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эм, үйлдвэрлэл, технологийн газрын дарга...  Н.Гэрэлт-Од

Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга  Д.Нарантуяа

Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга  Г.Цэцэнсанаа

Эрүүл мэндийн яамны Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга  Т.Хонгорзул

Эрүүл мэндийн яамны хуулийн хэлтсийн мэргэжилтэн  Д.Мөнхцэцэг

Эрүүл мэндийн яамны нярав  П.Энхболор

14210 Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII бай

Утас:263695

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Айвико интернэшл ХХК-ны Менежер

Б.Цогтбаяр 3822 5006368



Хаяг: Улаанбаатар хот, Хан-уу дүүрэг, 3-р хороо Эв нэгдлий гудамж
Утас: 77115730

Харилцах банк: Хаан банк

Дансны дугаар: 5022466390



МОНГОЛ УДС БЫН
ИРҮҮЛ МЭНДЭЙН ЯАМ

Улаанбаатар хот, Төрийн захирлын газар
Улаанбаатар хот, Төрийн захирлын газар
Улаанбаатар хот, Төрийн захирлын газар
Улаанбаатар хот, Төрийн захирлын газар

2020.11.09 8/4779

ТАНАЙ _____

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Эрүүл мэндийн яамнаас зарласан ЭМЯ/ЭЗХ/2020/10 дугаартай "Шинэ төрлийн коронавируст халдвар (ковид-19)-ын үед болон томуу, томуу тест өвчний үед шаардлагатай эм, тоног төхөөрөмж, жижиг хэрэгсэл" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт Багц 7 "Гепарин 5000 ОУН-5 мл ампул" 88,000,000 (наян найман сая) төгрөгөөр нийлүүлэхээр 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдөр ирүүлсэн танай тендерийг "хамгийн сайн үнэлэгдсэн" тендерээр шалгаруулж гэрээ байгуулах эрх олгож байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29.2-т заасны дагуу энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулна.

Шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгааг тендерийн хүчинтэй байх хугацаанд багтаан ирүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.

Харин Багц 8 "Эноксапарины натри 40мг-0.4 мл найрлага бүхий тариур" нийлүүлэх танай санал "хамгийн сайн" үнэлэгдсэн тендерээс өндөр үнэтэй байсан тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28.7 дахь хэсгийг үндэслэн шалгараагүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

ТӨРИЙН НАРИЙН БИЧИЙН
ДАРГА Я АМАРЖАРГАЛ

144209701

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН А/91 ТООТ ТУШААЛААР БАЙГУУЛАГДСАН
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ЗӨВЛӨМЖ**

2020 оны 11 дүгээр
сарын 04-ний өдөр

№02

Улаанбаатар хот

Гүйцэтгэгч сонгох, гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.2 дахь заалтыг үндэслэн ЗӨВЛӨХ нь:

1. “Шинэ төрлийн коронавируст халдвар (ковид-19)-ын үед болон томуу, томуу төст өвчний үед шаардлагатай эм, тоног төхөөрөмж, жижиг хэрэгсэл” тендерийн Багц-7 Гепарин 5000 ОУН-5 мл ампул нийлүүлэгчийг сонгон шалгаруулахад “хамгийн сайн” үнэлэгдсэн “Айвико-Интернэшнл” ХХК-тай 88,000,000 (наян найман сая) төгрөгөөр гэрээ байгуулахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Я.Амаржаргал/-д зөвлөж байна.

2. “Айвико-Интернэшнл” ХХК-тай Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу тендерийн хүчинтэй байх хугацаанд гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана уу.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА:



Г.ЦЭЦЭНСАНАА

ГИШҮҮД:



С.АЛТАНБАГАНА

Х.НАСАНЖАРГАЛ

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



П.ЦЭЦГЭЭ